



БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА
2024 оны I улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	8
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	12
Хөрөнгө оруулалт	13
Зээл.....	13
Цахим зээл	16
Ногоон зээл	18
Факторингийн тооцооны авлага.....	19
Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө.....	19
Санхүүгийн бус хөрөнгө	20
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	21
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	22
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр.....	23
Бусад эх үүсвэр	23
ББСБ-аас гаргасан өрийн бичиг.....	24
Төслийн зээлийн санхүүжилт	24
Бусад санхүүгийн өр төлбөр.....	25
Санхүүгийн бус өр төлбөр	25
Өөрийн хөрөнгө	25
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	26
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	27
Хуримтлагдсан ашиг	27
Ашигт ажиллагаа	28
Гадаад валютын арилжааны мэдээ	29
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	30
Дүгнэлт	31
Актив, пассивын бүтэц.....	31
Ашигт ажиллагаа	32
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	32

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 4 Харилцагч,зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 14 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	15
Хүснэгт 16 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	15
Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)	16
Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд	16
Хүснэгт 19 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/	18
Хүснэгт 20 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	19
Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/	19
Хүснэгт 22 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	20
Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	21
Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээгээр татсан хөрөнгө /харилцагчаар, тэрбум төгрөгөөр/	23
Хүснэгт 25 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	23
Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	23
Хүснэгт 27 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	25
Хүснэгт 28 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	25
Хүснэгт 29 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/	26
Хүснэгт 30 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	27
Хүснэгт 31 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	27
Хүснэгт 32 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/	27
Хүснэгт 33 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/.....	28
Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	28
Хүснэгт 35 2024 оны I улирлын байдлаарх валют арилжааны мэдээ (сая төгрөгөөр)	29
Хүснэгт 36 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	30

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	14
Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/.....	14
Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/	15
Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 12 ангиллаар/.....	18
Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	21
Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	22
Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	22

Зураг 11 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	24
Зураг 12 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	26
Зураг 13 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	28

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2024 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 531 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 17 ББСБ буюу 3.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 95 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 24 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ, финтек зээлийн үйлчилгээ үзүүлж байгаа 50 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2020-I	2021-I	2022-I	2023-I	2024-I
Шинээр олгосон	3	1	6	6	15
Хүчингүй	1	3	11	5	13
Түдгэлзүүлсэн	18	-	4	1	7
Сэргээсэн	1	5	5	10	9
Нийт ББСБ	540	530	529	514	531
Үүнээс: ХОН	75	76	85	94	95
Үүнээс: ГХО	28	30	28	25	24
Салбар	273	298	393	428	462
Төлөөлөгч	9	8	8	7	11

2024 оны I улирлын байдлаар 15 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 13 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 7 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 9 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2023-I	2024-I	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	3,702.1	5,062.1	36.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	8.0%	9.2%	1.2%
Нийт өөрийн хөрөнгө	2,316.3	2,917.7	26.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	51.5%	48.7%	-2.8%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,361.1	1,655.7	21.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	84.1%	100.0%	15.9%
Нийт зээл	2,864.0	4,249.5	48.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	12.2%	14.4%	2.2%
Нийт орлого	258.5	378.1	46.3%
Нийт зарлага	159.0	232.3	46.1%
Цэвэр ашиг	99.6	145.9	46.5%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 36.7 хувиар өсөж, банкны салбарын 9.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын хувь нийлүүлсэн хөрөнгөтэй тэнцэж байгаа нь өмнөх оны

мөн үетэй харьцуулахад 16.0 пунктээр өссөн дүн юм.

2024 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 36.7 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр өсөж 5.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 98.4 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 55.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 44.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 46.3 хувиар буюу 119.6 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 46.1 хувиар буюу 73.3 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 46.5 хувиар буюу 46.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2023-I	2024-I	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо		514	531	17	3.3%
1	Зээл	477	472	-5	-1.0%
<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>		305	289	-16	-5.2%
2	Факторинг	47	61	14	29.8%
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	29	1	3.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	6	1	20.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	40	47	7	17.5%
6	Гадаад валютын арилжаа	139	167	28	20.1%
<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>		36	56	20	55.6%
7	Итгэлцэл	69	80	11	15.9%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	24	37	13	54.2%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 531 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 88.9% нь буюу 472 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 54.4% нь буюу 289 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 167 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 31.5 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 56 ББСБ нийт ББСБ-уудын 10.5 хувийг бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын тоо 5.2 хувиар буурсан бол гадаад валют арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 55.6 хувиар өсжээ.

Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 54.2 хувиар өссөн нь бусад төрлийн үйлчилгээтэй харьцуулахад хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар “богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” гэж тодорхой гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэхийг ойлгодог. Зохицуулалтын хувьд ББСБ-ын худалдан авах үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь өөрийн

хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй байхаар журамласан байдаг.

Салбарын сүүлийн улирлуудын санхүүгийн тайлангийн нэгтгэлээс харахад ББСБ нь тухайн төрлийн үйлчилгээг зөвшөөрөлгүй эрхлэх нь нэмэгдсэн тул ХШЗГ-аас холбогдох арга хэмжээг авснаар 2024 оны I улирлын байдлаар богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрлийн тоо огцом нэмэгдсэн байна.

Бусад төрлийн үйлчилгээний хувьд итгэлцлийн үйлчилгээ 15.9 хувиар, факторинг 29.8 хувиар, гадаад валют арилжаа 20.1 хувиар тус тус өссөн байна.

2024 оны I улирлын тайлан мэдээний ирц 97.7% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 531 ББСБ-аас 519 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 2 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 10 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

ББСБ-ууд хөрөнгийн зах зээлд гарч, нээлттэй хувьцаат компани болох, банк банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагааг эрхлэх, олон улсаас хөрөнгө оруулалт татах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр нягтлан бодох бүртгэл, тайлагналыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэх, салбарын нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг шинэчлэх, зайлшгүй шаардлага үүссэн.

Үүний дагуу “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Сангийн сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/226/528 тоот тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд ББСБ-ууд энэхүү журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Шинэчлэн журамд төсөлд СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр, СТОУС-13 Бодит үнэ цэнийн хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа зэрэг СТОУС, НББОУС-ын дагуу санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих, ажил гүйлгээний бүртгэлийг дэлгэрэнгүй байдлаар тусгасан.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2024 оны I улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 88.5 хувь буюу 514 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 84.0 хувь буюу 432 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 472 ББСБ-ын 99.4 хувь буюу 469 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д

заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 76 ББСБ, 3,708 удаагийн тохиолдлоор, 470.3 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ” гэж заасны дагуу нэр бүхий 4 ББСБ, 199 удаагийн тохиолдлоор, 2.1 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2024 оны I улирлын байдлаар нийт 516 ББСБ-аас 1,293.0 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 89.1% буюу 461 ББСБ 1,152.1 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2024 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 33,850 хувьцаа эзэмшигчдийн 531 ББСБ, 463 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар, 5,385 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 9 дүүрэгт давхардсан тоогоор 4.5 сая харилцагч, 1.8 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар өсөж давхардсан тоогоор 4,458,031-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 38.9 хувиар өсөж 1,800,942-г хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,458,031	3,702,625	215,591	4,242,440	33,421	4,341,313	35,168	214,946	106,651
Үүнээс: Эмэгтэй	2,428,434	2,009,634	115,605	2,312,829	23,456	2,369,422	19,832	117,102	56,329
Эрэгтэй	2,026,068	1,692,017	97,109	1,928,959	8,713	1,968,475	15,278	97,546	50,009
Хуулийн этгээд	3,529	974	2,877	652	1,252	3,416	58	298	313
Итгэмжлэгчдийн тоо	11,151	11,150	2,312	8,839	-	10,630	5	6,085	352
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,269	1,216	76	1,193	-	984	-	639	352
Зээлдэгчдийн тоо	1,800,942	1,081,471	179,650	1,621,292	63	1,685,009	34,383	214,946	106,651
Хэвийн	1,610,305	941,614	149,316	1,460,989	28	1,512,454	28,019	177,474	89,961
Хугацаа хэтэрсэн	57,080	42,484	7,749	49,331	1	52,283	1,895	11,840	3,793
Чанаргүй:	133,557	97,373	22,585	110,972	34	120,272	4,469	25,632	12,897
-Хэвийн бус	36,201	25,010	6,697	29,504	9	33,292	1,320	7,622	3,061
-Эргэлзээтэй	31,350	23,644	3,773	27,577	3	27,701	1,309	5,947	2,739
-Муу	66,006	48,719	12,115	53,891	22	59,279	1,840	12,063	7,097
Зээлдэгчдийн насжилт	1,799,032	1,080,530	178,365	1,620,667	63	1,683,212	34,325	214,648	106,338
18-35 насны	1,099,142	618,029	74,659	1,024,483	-	1,029,960	19,011	125,987	60,994
36-45 насны	435,307	280,609	58,140	377,167	63	404,335	9,018	56,498	27,571
46-55 насны	208,119	136,238	32,736	175,383	-	195,415	4,625	24,605	13,142
55-аас дээш	56,464	45,654	12,830	43,634	-	53,502	1,671	7,558	4,631
Зээлдэгчдийн боловсрол	1,799,032	1,080,530	178,365	1,620,667	63	1,683,212	34,325	214,648	106,338
-Дээд	962,037	651,567	97,139	864,898	63	899,116	16,976	125,836	70,278
-Тусгай дунд	170,988	87,782	17,093	153,895	-	158,335	3,674	20,233	14,617
-Бүрэн дунд	479,261	248,320	45,149	434,112	-	444,077	11,931	57,900	15,282
-Дунд	133,686	79,874	8,892	124,794	-	129,935	1,324	8,602	5,064
-Бага	53,060	12,987	10,092	42,968	-	51,749	420	2,077	1,097

/Финтек ББСБ-ууд финтек уламжлалт зээл хослуулан олгодог болно/

Нийт харилцагчдын 95.2% буюу 4,242,440 нь зээлдэгчдийн 90.0% буюу 1,621,292 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 4.8% буюу 215,591 нь, зээлдэгчдийн 10.0% буюу 179,650 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 33,421 буюу нийт харилцагчдын 0.7 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2020-I	2021-I	2022-I	2023-I	2024-I	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	8,104	17,339	21,788	28,353	33,850	5,497	19.4%
Ажилчдын тоо	3,168	3,517	4,322	4,735	5,385	650	13.7%
Харилцагчдын тоо	2,203,682	3,481,431	4,645,134	3,862,489	4,458,031	595,542	15.4%
Зээлдэгчдийн тоо	425,859	610,068	1,453,685	1,297,025	1,800,942	503,917	38.9%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.0%	2.9%	3.1%	3.1%	3.7%	0.6 пункт	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар буюу 5,497-аар өсөж 33,850-д хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.9 хувь буюу 32,799 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 2,847 буюу 3.1% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 2,774 буюу 8.2% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа

эзэмшигчид байгаа бол 217 буюу 0.6% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	33,850	33,000	1,912	31,938	79	33,630	217	32,799	2,774
Нийт ажилтнуудын тоо	5,385	3,164	2,724	2,661	147	4,820	283	466	446
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	3,128	1,815	1,647	1,481	76	2,796	182	281	263
Эрэгтэй ажилтны тоо	2,257	1,349	1,077	1,180	71	2,024	101	185	183

Хөдөө орон нутгийн 95 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	531	80	481	50	56	436	95	5	526	25
1 Зээл	472	80	422	50	-	379	91	5	467	25
2 Факторингийн үйлчилгээ	61	30	43	18	-	58	1	3	58	3
3 Төлбөрийн баталгаа гаргах	29	18	21	8	-	27	1	2	27	4
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	5	-	6	-	5	-	1	5	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	47	21	30	17	-	44	3	3	44	3
6 Гадаад валютын арилжаа	167	35	145	22	56	151	15	4	163	7
7 Итгэлцлийн үйлчилгээ	80	80	51	29	-	75	3	5	75	6
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	37	23	23	14	-	33	2	2	35	3
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 81.7% буюу 420 ББСБ, салбаруудын 63.6% буюу 272 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 18.3% буюу 94 ББСБ, салбаруудын 36.4% буюу 156 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2023 оны I улирлын байдлаар 94 ББСБ-ын 428 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 61.8 хувийг 13 ББСБ-ын 264 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	436	281	717	100.0%
Сүхбаатар дүүрэг	141	38	179	25.0%
Чингэлтэй дүүрэг	124	34	158	22.0%
Баянзүрх дүүрэг	50	69	119	16.6%
Баянгол дүүрэг	71	41	112	15.6%
Хан-Уул дүүрэг	40	33	73	10.2%
Сонгинохайрхан дүүрэг	9	53	62	8.6%
Багануур дүүрэг	1	7	8	1.1%
Налайх дүүрэг	-	5	5	0.7%
Багахангай дүүрэг		1	1	0.1%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай, Дархан-Уул аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	95	181	276	100%
Архангай аймаг	3	7	10	3.6%
Баян-Өлгий аймаг	3	4	7	2.5%
Баянхонгор аймаг	4	8	12	4.3%
Булган аймаг	2	2	4	1.4%
Говь-Алтай аймаг	1	2	3	1.1%
Говьсүмбэр аймаг	3	3	6	2.2%
Дархан-Уул аймаг	7	13	20	7.2%
Дорноговь аймаг	1	10	11	4.0%
Дорнод аймаг	5	14	19	6.9%
Дундговь аймаг	-	6	6	2.2%
Завхан аймаг	2	5	7	2.5%
Орхон аймаг	11	17	28	10.1%
Өвөрхангай аймаг	11	13	24	8.7%
Өмнөговь аймаг	2	16	18	6.5%
Сүхбаатар аймаг	5	7	12	4.3%
Сэлэнгэ аймаг	7	12	19	6.9%
Төв аймаг	18	7	25	9.1%
Увс аймаг	4	8	12	4.3%
Ховд аймаг	1	7	8	2.9%
Хөвсгөл аймаг	2	10	12	4.3%
Хэнтий аймаг	3	10	13	4.7%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2024 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 5.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.7 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 98.4 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2023-I		2024-I		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,583,745.1	96.8%	4,819,018.8	95.2%	1,235,273.7	34.5%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	513,663.2	13.9%	588,166.5	11.6%	74,503.3	14.5%
Хөрөнгө оруулалт	33,245.3	0.9%	57,563.6	1.1%	24,318.3	73.1%
Зээл (цэврээр)	2,698,572.6	72.9%	4,037,422.8	79.8%	1,338,850.2	49.6%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	9,639.7	0.3%	20,874.4	0.4%	11,234.7	116.5%
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	-	-	1,651.7	0.0%	1,651.7	0.0%
Бусад санхүүгийн хөрөнгө	328,624.3	8.9%	113,339.8	2.2%	(215,284.5)	-65.5%
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	118,332.7	3.2%	243,113.6	4.8%	124,780.9	105.4%
Санхүүгийн бус бусад хөрөнгө	-	-	92,208.3	1.8%	92,208.3	0.0%
Үндсэн хөрөнгө (цэврээр)	118,332.7	3.2%	150,905.3	3.0%	32,572.6	27.5%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,702,077.8	100.0%	5,062,132.4	100.0%	1,360,054.6	36.7%


2024 оны I улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 9.2 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 14.4 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2019 оны мөн үед 1.4 их наяд төгрөг байсан бол 2024 оны I улирлын байдлаар 3.6 дахин өсөж 5.1 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь нийт зээлийн үлдэгдэл 4.4 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 97.6 хувь буюу 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 372 ББСБ, 0.9 хувь буюу 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 20 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.5 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 139 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	4,177.2	137	82.5%	25.8%	11.3	1	6.9	1	-	-
2.5-5.0 тэрбум	763.0	235	15.1%	44.3%	10.6	3	11.4	3	5.4	2
1.9-2.5 тэрбум	45.8	20	0.9%	3.8%	-	-	4.4	2	4.5	2
1.4-1.9 тэрбум	11.4	7	0.2%	1.3%	2.9	2	4.9	3	-	-
0.6-1.4 тэрбум	32.1	32	0.6%	6.0%	8.8	10	13.7	13	7.2	7
0.6 тэрбум хүртэлх	32.7	100	0.6%	18.8%	-	-	16.6	55	16.1	45
НИЙТ	5,062.1	531	100.0%	100.0%	33.6	16	57.9	77	33.1	56

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 2.8 их наяд төгрөг байгаа нь нийт активын 55.4 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 2.4 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 57.5 хувийг бүрдүүлж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 74.5 тэрбум төгрөгөөр буюу 14.5 хувиар өсөж 588.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 16.1% нь бэлэн мөнгө, 70.6% нь 3 хүртэлх сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, 1.0% нь мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 12.4% нь 3-аас дээш сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Дүн	Итгэлшлэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	588.2	301.1	352.7	235.5	28.0	572.6	15.6	88.4	93.8
Бэлэн мөнгө	94.4	5.8	90.5	4.0	20.6	86.6	7.9	0.3	4.3
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	415.0	244.9	230.6	184.5	7.1	408.4	6.6	87.9	85.4
Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	5.6	5.0	1.5	4.2	-	5.6	0.0	0.2	0.2
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3-аас дээш сарын хугацаатай)	73.1	45.4	30.2	42.8	0.3	72.1	1.0	(0.0)	3.9

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл 25.6% нь уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгө, 1.7% нь финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгө байгаа бол эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 73.6% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Хөрөнгө оруулалт

ББСБ-уудын хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 73.1% буюу 24.3 тэрбум төгрөгөөр өсөж, 2024 оны I улирлын байдлаар 25 ББСБ 57.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын 0.7% буюу 409.3 сая төгрөгийг хадгаламжийн сертификат, 99.3% буюу 57.2 тэрбум төгрөгийг үнэт цаасаарх хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	57,563.6	53,924.6	5,960.9	51,602.7	1.0	56,465.6	1,097.9	24,061.0	19,293.5
Хадгаламжийн сертификат	409.3	399.3	409.3	-	-	409.3	-	-	-
Үнэт цаас	57,154.3	53,525.3	5,551.6	51,602.7	1.0	56,056.3	1,097.9	24,061.0	19,293.5
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	37,964.8	35,165.5	3,632.2	34,332.6	1.0	36,866.9	1,097.9	16,125.3	16,125.3
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас	15,058.9	15,058.9	1,075.0	13,983.9	-	15,058.9	-	4,663.9	-
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	3,120.1	3,119.1	2.0	3,118.1	-	3,120.1	-	3,118.1	3,118.1
Барьцаанд байгаа үнэт цаас	399.4	-	399.4	-	-	399.4	-	-	-
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	721.5	292.2	443.0	278.6	-	721.5	-	153.8	50.2
(Үнэт цаасны эрсдэлийн сан)	110.4	110.4	-	110.4	-	110.4	-	-	-

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 37 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 32 ББСБ санхүүгийн тайлангаар хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 25 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна. Иймээс 7 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 49.6% буюу 1.3 тэрбум төгрөгөөр өсөж 2024 оны I улирлын байдлаар 4.2 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 212.0 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 4.0 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 14 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэлтэй	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Зээл (цэврээр)	4,037,422.77	2,820,889.15	1,774,443.13	2,262,979.65	1,914.00	3,968,733.16	68,689.62	775,033.52	638,296.22
Зээл	4,249,455.86	2,955,105.91	1,878,710.91	2,370,744.95	2,028.53	4,174,127.19	75,328.67	801,784.67	660,038.96
Хэвийн зээл	3,644,912.49	2,575,937.15	1,569,149.13	2,075,763.36	1,852.58	3,582,770.96	62,141.53	709,109.85	578,653.56
Анхаарал хандуулах зээл	151,836.31	105,758.09	70,663.90	81,172.40	0.55	149,864.97	1,971.34	30,741.93	26,735.04
Чанаргүй зээл	281,997.60	174,251.48	146,604.25	135,393.35	175.40	273,310.38	8,687.22	37,072.83	32,118.40
-Хэвийн бус зээл	74,497.58	47,076.03	39,172.82	35,324.76	78.33	72,587.57	1,910.01	14,654.21	11,760.37
-Эргэлзээтэй зээл	68,733.89	45,692.09	33,326.00	35,407.89	4.30	67,168.55	1,565.33	9,389.85	6,255.72
-Муу зээл	138,766.14	81,483.36	74,105.43	64,660.71	92.77	133,554.26	5,211.88	13,028.77	14,102.31
(ЗЭС)	212,033.09	134,216.76	104,267.78	107,765.31	114.53	205,394.04	6,639.05	26,751.15	21,742.74
Зээлийн хойшлогдсон төлбөр	185.95	25.22	160.73	25.22	-	185.95	-	-	-
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	170,895.41	99,184.40	92,454.35	78,441.06	-	168,366.82	2,528.58	24,860.06	22,531.97
Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	-	-	-	-	-	-	-	-	-

(Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно)

Шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд зааснаар “Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна” гэж тодорхойлсон.

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг 1 ББСБ 2.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан ба тухайн ББСБ-ын зээлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 2024.03.20-ны өдрийн тогтоолоор хүчингүй болгосон байна. Тайлант улиралд ББСБ-ууд 2.5 их наяд төгрөгийн зээлийг 3.6 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 2.1 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2024 оны I улирлын байдлаар 1.8 сая зээлдэгчийн 4.1 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



(Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн багцын нийлбэрээр тооцсон)

Зээлийн багцын 89.4 хувийг буюу 3.6 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.7 хувийг буюу 151.8 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 6.9 хувийг буюу 282.0 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.7 пунктээр өссөн бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.7, 1.0 пунктээр буурсан байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 433.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 48.9%-д буюу 212.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2024 оны I улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 10.6% байна.

Олгосон зээлийн 91.1% буюу 1.3 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 8.9% буюу 127.8 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 91.2% буюу 1.2 их наяд төгрөг нь иргэдээс, 8.8% нь буюу 113.0 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.


Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	12,353.7	0.49%	8,380.8	0.4%	37,803.5	0.9%
2.	Уул уурхай, олборлолт	9,227.4	0.4%	7,057.0	0.3%	59,025.7	1.4%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	9,363.0	0.4%	9,504.3	0.5%	33,510.5	0.8%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1,106.9	0.0%	802.9	0.0%	5,553.7	0.1%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	383.0	0.0%	366.9	0.0%	2,041.2	0.1%
6.	Барилга	50,490.0	2.0%	53,014.7	2.5%	238,417.3	5.8%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	187,030.0	7.5%	154,211.1	7.3%	428,981.7	10.5%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	41,684.6	1.7%	36,988.8	1.8%	104,216.9	2.6%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	42,024.2	1.7%	23,274.5	1.1%	142,840.0	3.5%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	28,255.5	1.1%	22,147.8	1.0%	119,571.2	2.9%
11.	Мэдээлэл холбоо	2,885.8	0.1%	3,403.1	0.2%	11,922.8	0.3%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	51,900.9	2.1%	40,716.9	1.9%	76,557.3	1.9%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6,777.8	0.3%	7,025.7	0.3%	29,125.1	0.7%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1,373.6	0.1%	1,257.0	0.1%	4,228.7	0.1%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7,125.2	0.3%	6,581.7	0.3%	19,801.9	0.5%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,094.0	0.0%	733.7	0.0%	2,567.9	0.1%
17.	Боловсрол	6,622.6	0.3%	21,168.4	1.0%	17,121.5	0.4%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	6,142.4	0.2%	3,961.8	0.2%	16,533.5	0.4%
19.	Бусад	2,040,900.1	81.4%	1,709,337.4	81.0%	2,728,926.1	66.9%
	<i>Иргэнд олгосон зээл</i>	2,317,408.6	92.4%	1,952,607.0	92.5%	3,613,103.4	88.6%
	<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>	189,332.3	7.6%	157,327.4	7.5%	465,643.0	11.4%
	НИЙТ	2,506,740.9	100.0%	2,109,934.4	100.0%	4,078,746.4	100.0%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 81.4% буюу 2.0 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 7.5% буюу 187.0 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 81.0% буюу 1.7 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 7.3% буюу 154.2 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Тайлант улиралд олгосон 2.1 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 25.6 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 21.3 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 4.1 их наядын зээлийн 54.4 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 22.2 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 9.6 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 16 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	2,317.4	92.4%	1,952.6	92.5%	3,613.1	88.6%
Хэрэглээнд зориулсан зээл	1,723.4	68.7%	1,445.5	68.5%	2,220.3	54.4%
<i>Үүнээс: Автомашинд зориулсан зээл</i>	<i>327.7</i>	<i>13.1%</i>	<i>206.3</i>	<i>9.8%</i>	<i>906.6</i>	<i>22.2%</i>
Бизнес зориулсан зээл	303.9	12.1%	252.8	12.0%	824.6	20.2%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	32.4	1.3%	36.3	1.7%	154.2	3.8%
Бусад зээл	257.7	10.3%	218.0	10.3%	414.0	10.1%
Хуулийн этгээдэд олгосон зээл	189.3	7.6%	157.3	7.5%	465.6	11.4%

Бизнесийн зээл	150.5	6.0%	118.6	5.6%	392.1	9.6%
Автомашинны зээл	2.7	0.1%	3.7	0.2%	9.9	0.2%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	1.7	0.1%	0.9	0.0%	10.7	0.3%
Бусад зээл	34.4	1.4%	34.1	1.6%	52.9	1.3%
НИЙТ	2,506.7	100.0%	2,109.9	100.0%	4,078.7	100.0%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй финтек зээлийн үйлчилгээг 2024 оны I улирлын байдлаар 50 ББСБ үзүүлж байна.

Тайлбар: Жилийн эцсийн байдлаар 55 ББСБ финтек зээлийн үйлчилгээ үзүүлж байсан бол 5 ББСБ тогтоосон хугацаанд зөвшөөрөл аваагүй тул бүртгэлээс хасаж холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	3,244,263,082.4	79.5%	284,916.0	15.8%	11,386.7
Цахим зээл	834,483,315.8	20.5%	1,516,026	84.2%	550.4
Нийт	4,078,746,398.1	100.0%	1,800,942	100.0%	2,264.8

2024 оны I улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1.5 сая зээлдэгчийн 834.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 84.2 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 20.5 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 550.4 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 20.7 дахин бага байна.

2024 оны I улирлын байдлаар “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-д заасан шаардлагыг хангаж Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн 50 ББСБ байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар 55 ББСБ финтек зээлийн үйлчилгээ үзүүлж байсан бол 5 ББСБ тогтоосон хугацаанд зөвшөөрөл аваагүй тул бүртгэлээс хассан. Иймд тухайн 5 ББСБ-д Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	Апп нэр	Бүртгүүлсэн огноо
1	"Лэндмн ББСБ" ХХК	LendMN	2023.06.20-№7/2550
2	"Соно финтек ББСБ" ХХК	Sono Mongolia	2023.03.03-№7/895
3	"Мобифинанс ББСБ" ХХК	Monpay	2023.06.20-№7/2540
4	"Инвекор хэтэвч ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.08-№7/1871
5	"Тус финтек ББСБ" ХХК	Tus fintech	2023.05.19-№7/2125
6	"ТОКИ ББСБ" ХХК	Toki	2023.06.20-№7/2549
7	"Кэйш флов финанс ББСБ" ХХК	Tugrug App	2024.02.21-№7/632
8	"Инвекор ББСБ" ХХК	InvesCore	2023.08.25-№7/3350
9	"Таван богд финанс ББСБ" ХХК	PayOn.mn	2023.07.04-№7/2826
10	"Нөмөр кредит ББСБ" ХХК	Numur	2023.03.03-№7/890
11	"Сэндли ББСБ" ХХК	Sendly	2023.07.04-№7/2821
12	"Ардкредит ББСБ" ХХК	Ard	2023.12.22-№7/4873
13	"Нэт капитал финанс корпораци ББСБ" ХХК	NetPay	2023.07.04-№7/2825
14	"Омни капитал ББСБ" ХХК	Moni	2023.07.05-№7/2869
15	"Хатан суудал инвест ББСБ" ХХК	Zeely	2023.03.03-№7/894
16	"Ашид капитал ББСБ" ХХК	Simple.mn	2023.11.10-№7/4317
17	"Дэвжих нэхий ББСБ" ХХК	Money-T	2023.12.22-№7/4870
18	"Очир ундраа ОМЗ ББСБ" ХХК	Opay MN	2023.08.25-№7/3351
19	"Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК	BiD	2023.08.25-№7/3353
20	"Ньюстар финанс ББСБ" ХХК	Lite+	2023.06.20-№7/2553
21	"Номин юнити ББСБ" ХХК	Nsf.mn	2023.06.20-№7/2552
22	"Номин юнити ББСБ" ХХК	OmniWay	2024.02.21-№7/634
23	"Гэрэлфинанс ББСБ" ХХК	Gerel	2023.05.08-№7/1872
24	"Энт кредит инвестмент ББСБ" ХХК	EntCreditMN	2023.03.03-№7/891
25	"Мөнгөнзоос кредит ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.24-нд мэдэгдсэн.
26	"Цогзолфинанс ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.23-нд мэдэгдсэн.
27	"Говьфинанс ББСБ" ХХК	CashOne	2023.08.25-№7/3354
28	"Грийн-Инвестмент ББСБ" ХХК	Gate.mn	2023.07.04-№7/2827
29	"Финрүүт-инвестмент ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.24-нд мэдэгдсэн.
30	"Жи Эс Би капитал ББСБ" ХХК	Prime	2024.02.21-№7/631
31	"Хас хаан ББСБ" ХХК	ХАСХААН	2023.06.20-№7/2551
32	"Их Монгол кредит ББСБ" ХХК	Ikh Mongol Credit	2024.02.21-№7/633
33	"Гурван зуун жар финанс ББСБ" ХХК	Minu pay	2023.07.04-№7/2822

33	"Жи би си си ББСБ" ХХК	E-zeel	2023.03.03-№7/889
34	"Зээл Эм Эн платформ ББСБ" ХХК	Zeel.mn	2023.07.04-№7/2828
35	"Нанокапитал ББСБ" ХХК	Nano Capital	2023.07.04-№7/2824
36	"Монголиа импакт финанс ББСБ" ХХК	Qmoni	2023.08.25-№7/3356
37	"Есөн финанс ББСБ" ХХК	MetaLend	2023.08.25-№7/3352
38	"Онч-Энх ББСБ" ХХК	Ugloo	2023.03.30-№7/1297
39	"Инвеско фонд ББСБ" ХХК	IF.mn	2023.08.25-№7/3349
40	"Изи пэй норбула ББСБ" ХХК	Easypay.mn	2023.12.22-№7/4867
41	"Микрокредит ББСБ" ХХК	Easy	2023.12.22-№7/4871
42	"Гоулдман инвестмент групп ББСБ" ХХК	Goldpay	2023.08.25-№7/3355
43	"Дарь финанс ББСБ" ХХК	Pocket.mn	2024.03.01-нд мэдэгдсэн.
44	"Есөн эрдэнэ финанс ББСБ" ХХК	Leasing.mn	2023.03.30-№7/1298
45	"Магна профит энд инвестмент ББСБ" ХХК	Magna.mn	2024.02.21-№7/635
46	"Си И Си инвестмент ББСБ" ХХК	Pocket.mn	2024.04.24-нд мэдэгдсэн.
47	"Соломон инвестментс ББСБ" ХХК	M credit	2023.11.10-№7/4319
48	"Сэнд эм эн ББСБ" ХХК	SendMN	2024.02.21-№7/636
49	"Франкфурт капитал ББСБ" ХХК	Nar app	2023.07.04-№7/2823
50	"Эс ай си эй финанс ББСБ" ХХК	Khanguud	2023.12.22-№7/4872

Нийт

*/"Инвекор ББСБ" ХК-ийн Pocket аппликэйшнд бүртгэлтэй 7 ББСБ байна.
Зөвхөн аппликэйшнээр зээл олгож байгаа 7 ББСБ-ыг саарлаар тэмдэглэв/*

Ногоон зээл

